



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/Нос

Мандалговь

Коронавируст (ковид-19) цар тахалтай
тэмцэх арга хэмжээнд зардал гаргах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.4, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1 дэх заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 15 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдвар (Ковид-19)-ыг эмчлэх хуучин амбулаторийг түр эмнэлгээр зохион байгуулах болон ПГУ лабораторийн үйл ажиллагааг хэвийн явуулахад нэн шаардлагатай материал, тоног төхөөрөмжийн зардлыг хавсралтаар баталсугай.

2. Зардалд шаардагдах 7.756,000 (Долоон сая долоон зуун тавин зургаан мянган) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (М.Янжиндолгор) нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210572